

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

ЗҮҮН МОНГОЛЫН ХЭВЛЭЛЧДИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭВ ЗАГВАРЫН ОНЦЛОГ

Баягуд Яруу*

*Өвөр Монголын Их Сургууль болон Америкийн Индианагийн Их Сургуулийн хамтарсан хөтөлбөрийн докторант

Түлхүүр үг: Зүүн Монголын хэвлэлчид; зохион байгуулалтын хэлбэр, төлөвшүүлэлт, ажиллагаа

Юань, Мин, Чингийн үед монгол судлалын хүрээнд бурхны сургаал ба шүлгэнгийн ухаан чухал байрыг эзлэж байв. Бурхны сургаалын сонгодог бүтээлийн орчуулга тайлбарлал ба Энэтхэгээс үүссэн шүлгэнгийн ухааны онол нь урт хугацааны туршид Монголын эрдэмт-дийн журамлаад ирсэн эрдэм шинжилгээний хөөцөлдөл болно. Эрдэм шинжилгээний ахуй нөхцөл, судалгааны арга маягийн загварчлал зэрэг шалтгаанаас болж, “Монгол судлал”-д эрдэм шинжилгээний онцлог ба зохистой аргын онолын систем бүрэлдэж чадсангүй. Иргэн улсын үед нийгмийн ширүүн хувьсал ба соёлын шилжилт дунд Зүүн Монголын хэвлэлчдээс гэгээрүүлэх дэгийг өндөрт өргөж, хамтын үндсэн ертөнцийн үзлийг санаачлан, зохион байгуулалттайгаар тус орны эрдэм шинжилгээний хэв загварын онцлогийг эрэлхийлэх хүчирхэг замналаа эхлүүлсэн байна. Зохион байгуулалтын хэлбэр,

зохион байгуулалтын төлөвшүүлэлт, зохион байгуулалтын ажиллагаа нь Зүүн Монголын хэвлэлчдийн эрдэм шинжилгээний хөдөлгөөний орон нутагчлалтын гол онцлог болох юм.

Нэг. Зохион байгуулалтын хэлбэр. Бүлгэм, нийгэмлэг бол Зүүн Монголын хэвлэлчдийн эрдэм шинжилгээг өрнүүлэх үндсэн зохион байгуулалтын хэлбэр болно. Иргэн улсын үед Зүүн Монголд монгол соёлын түүхэнд харьцангуй нөлөөлөх хүчин бүхий бүлгэм, нийгэмлэг болох Монгол соёлыг шаардан давшуулах хурал, Монгол хурлын гэр ба Монгол утгын сургаалын хурал зэрэг нийгмийн бүлгэм, нийгэмлэг бий болсон байна. Эдгээр бүлгэм, нийгэмлэгийн ухуулагч ба гүйцэтгэгчийн олонх нь тухайн үед соёлын тавцанд анх гарч ирж байсан Зүүн Монголын бичгийн хүмүүс ба хэвлэлчид байв.

Монгол соёлыг шаардан давшуулах хурлыг Хээшингэ ба Гүэ дао фүгээс ухаалан сэдэж, 1929 онд Мүгдэнд байгуулав. Монгол хурлын гэр нь 1937 онд Манж улсын нийслэл Шинжинд байгуулагдаж, Хянганы ерөнхий балгадын дарга Жагар хурлын

дараагийн тушаалыг хариуцаж байв.Тэд нар голдуу “Монгол үндэстний соёлын хөгжилт, ард иргэдийн боловсролыг дээшлүүлж, монголчууд бусад үндэстнийг танин мэдрэх зөв танилтыг дээшлүүлэх”¹ зэрэг ажлыг өрнүүлж байсан юм.

Монгол утгын сургаалын хурал нь 1926 онд Бээжинд байгуулагдан, 1935 онд Кайлуд шилжэв.Монгол утгын сургаалын хурлын байгуулагдсан нь монгол үндэстний ойр үеийн соёлын түүхэндэх нэгэн чухал хэрэг болох юм.Түүний байгуулагдсан нь Монголын нийгмийн хувьсалтын тулгам шаардлагатай нийцсэн байна.Монгол утгын сургаалын хурал байгуулах хурлаарБөххишигийг хурлын даргаар сонгож,“Монгол утгын сургаалын хурлын хураангуй дүрэм”-ийг баталжээ.“Хураангуй дүрэм”-д“Тус хурал болбоос монгол утгаа сүвэгчлэн нягталж аливаа сургаал эрдмийг монгол утга дээрээ дэлгэрүүлэн, санал үзлийг шинэтгэн сайжруулж, монгол угсаатны оюун билгийг нээгдүүлэн гэгээрүүлээд, монгол угсаагийн утга соёлыг боловсруулан хөгжүүлэхийг гол зорилт болгомуй”² гэж хурал байгуулсан зорилтоо тодорхойлсон байдаг.

Зүүн Монголын хэвлэлчдийн эрдэм шинжилгээний хөдөлгөөн нь голдуу Монгол утгын сургаалын хурал ба Монгол соёлыг шаардан давшуулах хуралд төвлөрч байв.Эрдэм шинжилгээний солилцоо, соёл мэдлэгийн түгээмэлжүүлэл жич монголын ард олны соёл гэгээрлийг ахиулахаар зорилтоо болгосон бүлгэм болсны хувьд тус хоёр бүлгэм нь байгууллага, нэгж, сургууль, эмнэлгийн хороо, цэрэг ангийн дундаас гишүүн элсч бүлгэмийнхээ нөлөөлөх хүчнийг өргөтгөж байжээ. Жишээлбэл, 1935 онд Монгол утгын сургаалын хурал Кайлуд

шилжсэнээс хойш“Аливаа тус хурлын гол зорилтыг зөвшөөрч, дуртайяа тус хурлын тогтоосон ажлыг хийсүгэй хэмээх бөгөөд бас монгол утгаар өөрийн бодлого эл санаагаа бичиглэн гаргаж чадах монголчууд, эрс эмс хэмээх ба газар орон хэмээх ялгалгүйгээр цөм тус хурал дор шууд гуйн мэдүүлж, хурлын нөхөр болох”³зориг санааг бадруулан, 1944 он болоход нийт 175 гишүүнтэй болжээ. Хурлын олонхгишүүд нь албан хаагч, багш, эмч, цэрэг, тариачин, судлаач эсхүл зохиолчийн гаралтай хүмүүс байлаа. Бүлгэмийн зохион байгуулалтын жолоодлогоор 1934-1944 оны хооронд сургаалын хурлын сэтгүүл болох “Улаан барс” сэтгүүлд зохиол бүтээл нийтэлсэн гишүүн 60 гаруй байв.Тэднарын судалгаа нь хэл, түүх, утга зохиол, эм эмнэлэг, газар зүй, одон орон, шашин суртахуун ба шинжлэх ухааныгтүгээн дэлгэрүүлэх зэрэг өргөн хүрээг хамарч⁴, үндэстний соёл мэдлэгийн дамжуулга ба оюун ухааны сэхээрэлтэд чухал үйлдлээ бадруулсан байна.

Хоёр.Зохион

байгуулалтын төлөвлөлт. Иргэн улсын үеийн Зүүн Монголын хэвлэлчдийн бүлгэм, нийгэмлэг нь цөм түүний нийгэм-лэгийнхээ хөтөлбөр ба зохион байгуулалтын төлөвлөгөөтэй байдаг. Монгол соёлыг шаардан давшуулах хурал нь “Соёлын гэгээрэл, үндэстний мандал”-ыг хөтөлбөр болгож, монгол хурлын гэр нь “үндэстний соёлоо бадруулан ард олны хэв боловсролыг дээшлүүлэн, шашин суртахууны төрийн бодлогыг түгээмэлжүүлэх жич монгол үндэстэн хийгээд бусад эл үндэстний хоорондох нэвтэрэлцээг ахиулах”-аар зорилтоо болгож байв. “Монгол утгын сургаалын

хурлын хураангуй дүрэм"-ийн хоёр-дугаар зүйлд "Монгол утгаа сүвэгчилэн нягталж, аливаа сургаал эрдмийг монгол утга дээрээ дэлгэрүүлэн, санал үзлийг шинэтгэн сайжруулж монгол угсааны оюун билгийг нээгдүүлэн гэгээрүүлээд монгол угсаагийн утга соёлыг боловсруулан үзүүлэхээр гол зорилтоо болгоно" гэж заажээ. 1935 онд Монгол утгын сургаалын хурал Кайлуд шилжсэнээс хойш Бөххишигтэй хамтран "Хураангуй дүрэм"-д засвар оруулж, түүнийгээ "Улаан

барс" сэтгүүлийн дөрөвдүгээр дугаарт нийтэлсэн байна. "Хураангуй дүрэм"-ийг нийтлэх ажлыг түүнийг эрхлэн төсөвлөгч зохион байгуулсан бөгөөд ухаалаг чадварыг гүйцэд тусгасан байна. "Монгол утгын сургаалын хурлын хураангуй дүрэм"-ийн 6 дугаар зүйлд Монгол утгын

сургаалын хурлын эрдэм шинжилгээний ажиллагааг нарийвчлан ухаалан төсөвлөж, судал-гааны чиглэлээ дараах байдлаар тодорхойлсон байдаг. "А.Сүвэгчлэн нягтлах анги: 1. Судар түүх хийгээд газар зүй. 2. Зан ааль хийгээд дадал суртал. 3. Чуулган хошуудын улирж ирсэн үүсгэл төгсгөл. 4. Шашин суртлын дэлгэрч ирсэн шалтгаан. 5. Адуу мал тэжээх сургаал ба тариа төмс үйлдэх сургаал хийгээд эмчийн сургаал, жич тэжээврийг эмнэх сургаал. 6. Өөр зүйлийн монгол угсаатнаа одоо цагт асар чухал хэрэгсэх сургаал

эрдмийг бүрнээ сүвэгчлэн нягтал-муй. Б.Нийлүүлэн бодох анги: 1. Аливаа монгол хошуудын хүн амны бүх тоо. 2. Аливаа монгол хошуудын газар орны урт өргөний хэмжээ. 3. Аливаа монгол хошуудын сүм хийд хийгээд хуурагуудын бүх тоо. 4. Аливаа монгол хошуудын сургууль хийгээд сурагчдын бүх тоо. 5. Аливаа монгол хошуудын сургаал хийх насан дор төрсөн хүүхэд багадагшаа сургаал хийж буй сурагчдын бүх тоо. 6. Аливаа монгол

хошуудын тэжээвэр малын тоо хийгээд жил бүрийн өсвөр төлийн бүх тоо. 7. Аливаа монгол хошуудын тариалан шугуйн үр хуваарийн тоо хийгээд жил бүрийн хурааж авах хэмжээний бүх тоо. 8. Аливаа монгол хошуудын хүн амны жил бүрийн төрч нэмэх хэмжээ хийгээд үхэж унах хэмжээ. 9. Аливаа монгол хошуудын хятад хүний нүүн

сууж ахуйн бүх тоо. 10. Өөр зүйлийн монгол угсаатанд холбогдолтой бөгөөд нийлүүлэн бод-воос зохих хэрэг үй-лийг бүрнээ нийлүүлэн бодмуй. В.Сурвалжлан байцаах анги: 1. Аливаа монголын чуулган хошуудын хамаатай дүрэм хуулийн сайн муу тал. 2. Аливаа монголын чуулган хошуудын хамаатай газрын чанар нь юун дор зохицох. 3. Аливаа монголын чуулган хошуудын хамаатай зам нэвтрэлийн байдал. 4. Аливаа монголын чуулган хошуудын хамаатай өвчин тахлыг хэрхэн сэрэмжилж бүхий учир. 5. Аливаа монголын чуулган хошуудын хамаатай аж

«

***"Хураангуй дүрэм"-ийг нийтлэх
ажлыг түүнийг эрхлэн
төсөвлөгч зохион байгуулсан бөгөөд
ухаалаг чадварыг гүйцэд тусгасан
байна. "Монгол утгын сургаалын
хурлын хураангуй дүрэм"-ийн 6
дугаар зүйлд Монгол утгын
сургаалын хурлын эрдэм
шинжилгээний ажиллагааг
нарийвчлан ухаалан төсөвлөж,
судал-гааны чиглэлээ дараах
байдлаар тодорхойлсон байдаг***

»

амьдарч бүхий байдал. 6. Аливаа монголын чуулган хошуудын хамаатай сургаал хүмүүжлэл хийгээд шашин суртлын байдал. 7. Аливаа монголын чуулган хошуудын хамаатай уул ба мөрний ашиг хор. 8. Аливаа монголын чуулган хошуудын хамаатай монгол хятадын холилдон сууж буй ахуй байдал. 9. Өөр зүйлийн монгол угсаатанд холбогдолтой бөгөөд сурвалжлан байцааваас зохих хэрэг үйлийг бүрнээ сурвалжлан байцаамуй.

Г.Утга найруулгын анги: 1. Монгол утгаар үлгэр түүх зохиож орчуулах. 2. Монгол утгаар шүлэг дуулал бичиглэх. 3. Монгол утгаар жүжиг зохиох. 4. Монгол утгаар шинэ ангит сургаалыг тайлбарлан тэмдэглэх. 5. Монгол утгаар ерийн матаал ухааныг улируулан сонсгох. 6. Монгол утгаар нэрт эрдэмтний зохиолыг уламжлан тэмдэглэх. 7. Монгол утгаар шинэ гарсан хэрэг бодисын нэрийдэл хийгээд тогтсон сургаалын үгсийг зохион орчуулах. 8. Монголын эртний утгыг сүвэгчлэн нягтлах. 9. Өөр зүйлийн утга найруулгын хамаатай бүхнийг бүрнээ үүдэн гаргамуй; Д.Арга бодлого

анги: 1. Хүн амны тоогийн төрч өсөх хэмжээг хэрхэн нэмэгдүүлэх хийгээд үхэж унах хэмжээг хэрхэн цөөрүүлэх тухай. 2. Өвчин тахал ба гамшиг зовлонг хэрхэн урьдчилан сэрэмжлүүлэхийн тухай. 3. Мал тэжээх ба тариатарихыг хэрхэн сайжруулж сэрэмжлүүлэх тухай. 4. Сурган хүмүүжлэлийн хэргийг хэрхэн шамдаж дэвшүүлэхийн тухай. 5. Хүн орчлонгийн аж амьдралыг хэрхэн улируулан сайжруулахын тухай. 6. Засаг засалт ба цааз хуулийг хэрхэн засамжлан сайжруулах тухай. 7. Өөр зүйлийн монгол угсаатан хийгээд тус хурал дор холбогдолтой хэрэг үйлийг тухайбүрнээ бодлоголон гаргамуй”⁵. Иймэрхүү

нарийн тодорхой зохион байгуулалтын төлөвлөлт нь өнгөрсний эрдэм шинжилгээний хүрээнд маш ховор тохиолддог бөгөөд энэ нь эрдэм шинжилгээний шинэ хэв загварын жишээ болсон юм.

Гурав.Зохион байгуулалтын ажиллагаа.Орон нутгийн эрдэм шинжилгээний хэв загварын онцлогийн бүрэлдэл нь зохион байгуулалт, бүлгэм нийгэмлэгийн нарийн төлөвшүүлэлтээр дамжин эцэстээ түүний зохион байгуулалтын ажиллагаа дундаа биелэгдэх юм.Эртний ном бичгийн эмхэтгэн дэглэлт, зан үйлийн байцаан судлалт, үг хэлний дүрэмжил нь Зүүн Монголын хэвлэлчдийн орон нутгийн эрдэм шинжилгээний хэв загварын бүрэлдэлд хэрэгжүүлсэн зохион байгуулалтын ажиллагаа болно.

“Эртний бичиг хэвлэгдэхүүн нь тус биеэрээ өнгөрөгч үеийн тэдгээр шилдэг хэвлэгчдийн хэр түвшинг илтгэж байга юм.Ийнхүү тэд нар өөрийн өвөрмөц онцгой арга барилаа-раа эрдэм шинжилгээний соёлын бүтээн байгуулалтын эгнээнд оролцсон билээ... шинэ соёлын хөдөлгөөн дундах (хуучин соёлыг эмхэтгэн дэглэх) үзэл санааны урсгал нь таван сарын дөрвөний шинжлэх ухаан ардчиллын үзэл санааг шингээн авч, таван сарын дөрвөний үр бүтээлийг илрүүлсэн чухал нэгэн зүйл болсон юм.Тэр нь ХХ зууны эрдэм шинжилгээний үзэл санааны түүхийн нэгэн бүрэл-дэхүүн хэсэг болох юм”⁶.Олны мэдээжээр, эртний бичгийн эмхэтгэн дэглэлт нь нэг зүйлийн төв чанга эрдэм шинжилгээний ажиллагаа болох юм.“Монголын нууц товчоо”-г буулган бичсэн ба хэвлэсэн нь эртний бичгийн эмхэтгэн дэглэлтийн талаарах

хамаг их үр бүтээл болох юм. XX зууны 40-өөдөнд Мин улсын үеийн “Монголын нууц товчоо”-ны 12 боть ба 15 боть дэвтрийн суурь дээр Монгол утгын сургаалын хурал ба Тэргүүн ноёны ордны дармалын газар зэрэг иргэн улсын үеийн монгол хэвлэлийн байгууламжаас Кайлуд хэвлэгдсэн “Монголын нууц тууж”(Бөххишиг), Чуулалт хаалгат хэвлэгдсэн “Юань улсын түүх”(Хишигбат) ба “Алтан-Очирын орчуулсан “Монголын нууц товчоо” зэрэг адил бус хэвлэлийн “Монголын нууц товчоо”-г урьд өмнө хэвлэсэн байна. Үүний дотроос Кайлуд хэвлэгдсэн “Нууц товчоо”-г буулган бичсэн нь хамгийн нарийн оновчтой байж эрдэм шинжилгээний баримжаатай хэвлэл болжээ. Монголын нэрт эрдэмтэн Ц.Дамдинсүрэн гуайн хэлсэнчлэн: “Өвөр Монголын сэхээтэн хүмүүс “Нууц товчоо”-г хятад хэл ба хятад сийрүүлгээс хэдэн удаа монгол үсгээс буулгаж хэвлүүлсэн юм. Жишээ нь: Хишигбат, Бөххишиг, Алтан-Очир зэрэг хүмүүс “Нууц товчоо”-г монгол үсгээр буулгаж, 1940 оны орчим тус тус хэвлүүлжээ. Үүний дотроос хамгийн нягт хийсэн нь Бөххишиг болно. Бусдын орчуулгань олигтой эрдэм шинжилгээний бүтээл болж чадаагүй, зөвхөн сонирхогчдын бүтээл болжээ”⁷.

Зан үйлийн судалгааны талаар Зүүн Монголын хэвлэлчдээс их хэмжээний ардын аман зохиолын эмхэтгэн цуглуулалтын ажлыг хийсэн байна. Эдгээр эмхэтгэн цуглуусан ардын аман зохиолыг ардын дуу, зүйр сэцэн үг ба ураг хуримын ерөөл магтаал зэргээр ангилж болно. Үүнд ардын дууны агуулга хамгийн баялаг байж, голдуу архи барих, хайр сэтгэл, шашин суртахуун, ачлал журам, дурсан мөрөөдлийн агуулгатай холбогдоно.

Зүйр сэцэн үг нь хошин шог хэлбэрээр оршил тогтнол, ажил хөдөлмөр, гэр бүл, ёс суртахуун, зол жаргал, эрүүл чийрэг ба хувь тавилангийн талаарх гүн ёс учрыг уламжлан сургасан байна. Хуримын ёслолын ерөөл зэргийг эмхэтгэн цуглуулалтын ажлыг голдуу Найман хошуу ба Хишигтэн хошууд өрнүүлж, “Найман хошууны хэлмэрчийн үг” ба “Хишигтэн хошууны хэлмэрчийн үг”-ийг бүрэн бүтэн эмхэтгэсэн байна. Иргэн улсын үеийн Зүүн Монголын хэвлэлчдийн зан үйлийн байцаан судлалтын ажиллагаа нь “Монгол зан үйлийн ухааны судалгааны ажил жич бүхийл монгол соёлыг хөгжүүлэх ажилд нь суурь тавих нөхцөл бүрэлдүүлэн өгсөн явдал болно”⁸. Үг хэлний дүрэмжлийн талаар Ролгорзав, Бөххишиг, Чалуунга, Хасбат, Үнэнзаяат зэрэг хүмүүс 1936 оноос эхлэн хятадын тусгай нэр үгийн монгол орчуулга ба монгол хүний нэрийн хятад орчуулгын ажлыг хийсэн байна. Эдгээр ажлын үр бүтээл нь Бөххишиг, Ролгорзав зэрэг хүмүүсийн эрхлэн найруулсан “Монгол хятад аялгууг хослосон бичиг”-т нийт 1090 зурвас багтжээ. Зохиолч Ринчинхорлоогоос “Монгол утга хэлийг нийдэм түгээмэл болгохын өчүүхэн нөхвөр” гэх өгүүлэл туурвин орчуулгын хэлэнд оршиж байгаа асуудлыг дурдан нутгийн аялгууны уран зохиолын хэллэг дэх чухал шинжийг дурдсан байна.

Нэгтгэн дүгнэвэл, бүлгэмдэн нягтарсан зохион байгуулалтын хэлбэр, нарийн нягт зохион байгуулалтын төлөвшүүлэлт, үнэн бодитой зохион байгуулалтын ажиллагаа нь Зүүн Монголын хэвлэлчдийг эрдэм шинжилгээний ахуй нөхцөлийн хүчирдлээс мултруулан, үндсэндээ орон нутгийн эрдэм шинжилгээний хэв загварын онцлогийг бүрэлдүүлсэн байна.

Ишлэл

- ¹ Хирогава Сахо. 2007. Манж улсын монгол сонин, сэтгүүлийн үүсэл гарал болон хөгжилт // “Япон далайг хүрээлсэн судалгааны жилийн сэтгүүл”. № 14. х. 32.
- ² Бөххишиг. 1937. Монгол утгын сургаалын хурлын хураангуй дүрэм // “Улаан барс” сэтгүүл. №4.
- ³ Бөххишиг. 1937. Монгол утгын сургаалын хурлын хураангуй дүрэм. Наймдугаар зүйл // “Улаан барс” сэтгүүл. №4.
- ⁴ С.Отгонбаяр, Сэцэнцэнгэл, Хастунгалаг, Тунгалаг. 2013. Иргэн Улсын үеийн монгол үндэстний хэвлэлийн соёл судлал. Хөххот: Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. х.189-191
- ⁵ Бөххишиг. 1937. Монгол утгын сургаалын хурлын хураангуй дүрэм. Наймдугаар зүйл // “Улаан барс” сэтгүүл. №4.
- ⁶ Ө юн гүй. 2002. Жүн ухаа номын товчооны Хятадын орчин үеийн эрдэм шинжилгээний соёлд нэмэрлэсэн гавьяа зүтгэл // “Хэвлэл тархалтын судлал”. № 8. х.73 -74.
- ⁷ Ц.Дамдинсүрэн. 1977. Монгол уран зохиолын түүх. УБ. х.79.
- ⁸ Бээ. Сүх. 2003. Бөххишиг хийгээд “Улаан барс” сэтгүүлийн судлал. Хайлаар: Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. х.41.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Бөххишиг. 1937. Монгол утгын сургаалын хурлын хураангуй дүрэм. Наймдугаар зүйл // “Улаан барс” сэтгүүл. №4.

2. Бээ. Сүх. 2003. Бөххишиг хийгээд “Улаан барс” сэтгүүлийн судлал. Хайлаар: Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.
3. Дамдинсүрэн Ц. 1977. Монгол уран зохиолын түүх. УБ.
4. Отгонбаяр.С., Сэцэнцэнгэл, Хастунгалаг, Тунгалаг. 2013. Иргэн Улсын үеийн монгол үндэстний хэвлэлийн соёл судлал. Хөххот: Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.
5. Ө юн гүй. 2002. Жүн ухаа номын товчооныхятадын орчин үеийн эрдэм шинжилгээний соёлд нэмэрлэсэн гавьяа зүтгэл // “Хэвлэл тархалтын судлал”. № 8.
6. Хирогава Сахо. 2007. Манж улсын монгол сонин, сэтгүүлийн үүсэл гарал болон хөгжилт // “Япон далайг хүрээлсэн судалгааны жилийн сэтгүүл”. № 14.

Резюме

Статья посвящена вопросам возникновения и развития научно-просветительского движения групп и сообщества издателей монголов южной части Внутренней Монголии. Автор опираясь на исторические источники всесторонне показывает научно-просветительские деятельности таких известных просветителей и издателей, как Бөххишиг, Хишигбат, Алтан-Очир, Ролгорзав.